

## **МОНГОЛБАНКНЫ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь Зээлийн мэдээллийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн дагуу Монголбанкны зээлийн мэдээллийн санг бүрдүүлэх, зээлийн мэдээллийн үйлчилгээний найдвартай, тасралтгүй байдлыг хангах хүрээнд зээлийн мэдээллийг санг ашиглах, хяналт тавих харилцааг зохицуулахад оршино.

1.2. Мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгч нь мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсны үндсэн дээр Монголбанкны зээлийн мэдээллийн сантай мэдээлэл солилцоно.

1.3. Монголбанкны зээлийн мэдээллийн сан нь Зээлийн мэдээллийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасан мэдээллээс бүрдэх бөгөөд тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хамруулсан байна.

1.4. Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаанд Зээлийн мэдээллийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмыг баримтална.

### **Хоёр. Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаа**

2.1. Монголбанкны зээлийн мэдээллийн сан нь хуанлийн өдрүүдэд 24 цаг ажиллана.

2.2. Монголбанк нь дараах үйл ажиллагааг эрхэлнэ:

2.1.1. Зээлийн мэдээллийн санд цуглуулсан зээлийн мэдээллийг боловсруулж, хэрэглэгчид зээлийн лавлагаа, бусад бүтээгдэхүүн гаргах;

2.1.2. Санхүүгийн салбарын зохистой хяналт шалгалтыг хийх, эрсдлийг удирдахад дэмжлэг үзүүлэх статистик, тайлан мэдээгээр хангах;

2.1.3. Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаарх олон нийтийн санхүүгийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, харилцагчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, мэдээлэл нийлүүлэгч болон хэрэглэгч байгууллагуудтай хамтран ажиллах;

2.1.4. Монголбанкны Зээлийн мэдээллийн алба нь энэхүү журмын 1.1 дэх заалтыг хангах зорилгоор зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг эрхлэх.

### **Гурав. Монголбанкны эрх, үүрэг**

3.1. Монголбанк Зээлийн мэдээллийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

3.2. Монголбанк энэхүү журмын 3 дугаар зүйлийн 3.1-д зааснаас гадна дараах эрхтэй:

3.2.1. Мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгчийн мөн эсэхийг гэрчлэх баримтыг шалгасны үндсэн дээр энэхүү журмын 1 дүгээр хавсралт дахь гэрээ байгуулах, татгалзах, хүчингүй болгох;

3.2.2. Мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгчийн Монголбанкны зээлийн мэдээллийн санд хандах эрхийг олгох, зохицуулах, түдгэлзүүлэх, хаах;

3.2.3. Мэдээлэл нийлүүлэгчээс зээлийн мэдээллийн санд нийлүүлэгдсэн зээлийн мэдээлэлтэй холбоотой мэдээлэл, баримт, материалыг гаргуулан авах;

3.2.4. Санхүүгийн зуучлал, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар Зээлийн лавлагаанд шаардлагатай гэж үзсэн мэдээллийг тусгах, эс тусгах, мэдээлэлд өөрчлөлт оруулах арга хэмжээ авах;

3.2.5. Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн програм, техник тоног төхөөрөмжийг шинэчлэх хугацаанд зээлийн мэдээллийн үйл ажиллагааг тодорхой хугацаагаар зогсоох;

3.2.6. Зээлийн мэдээллийн санд шаардлагатай шинэчлэлийг гүйцэтгэх, найдвартай тасралтгүй байдлыг хангах, хүчин чадлыг нэмэгдүүлэх, үйлчилгээг боловсронгуй болгох зорилгоор хэрэглэгчээс хураамж, шимтгэл авах;

3.2.7. Монголбанкны үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөлд заасан хураамж, шимтгэлийг энэхүү журамд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд төлбөр төлөх эцсийн хугацаанаас хойш 6 сарын дараа мэдээлэл хэрэглэгчийн нэр дээр шүүхэд нэхэмжлэл гаргах.

3.3. Монголбанк энэхүү журмын 3 дугаар зүйлийн 3.1-д зааснаас гадна дараах үүрэгтэй:

3.3.1. Зээлийн мэдээллийн сангийн програм хангамжийг өөрчлөх, хөгжүүлэх, програмд гарсан алдаа доголдлыг хурдан шуурхай засах, техник тоног төхөөрөмжийн найдвартай, тасралтгүй үйл ажиллагааг хангах;

3.3.2. Мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгчид зээлийн мэдээллийн сангийн програм ашиглалт, мэдээлэл нийлүүлэлттэй холбоотой асуудлаар зааварчилгаа, зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;

3.3.3. Тусгай зөвшөөрөл хүчингүй болсон эсхүл татан буугдсан мэдээлэл нийлүүлэгчээс нийлүүлсэн зээлийн мэдээллийг зохицуулагч байгууллагын тодорхойлолтыг үндэслэн засварлах, устгах арга хэмжээ авах;

3.3.4. Шүүхийн шийдвэрийн дагуу мэдээлэл нийлүүлэгчээс Монголбанкны зээлийн мэдээллийн санд нийлүүлсэн зээлийн мэдээллийг засварлах, устгах;

3.3.5. Зээлийн мэдээллийн сангийн үнэн зөв, бодит байдлыг хангах зорилгоор мэдээлэл нийлүүлэгчид түүний нийлүүлсэн зээлийн мэдээллийн тайланг гаргаж өгөх;

3.3.6. Иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн өргөдөл, гомдлын дагуу мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгчтэй холбоотой асуудлыг судлах, шийдвэрлэх, хариу хүргүүлэх.

**Дөрөв. Санхүүгийн зохицуулах хорооны эрх, үүрэг**

#### 4.1. Санхүүгийн зохицуулах хороо дараах эрхтэй:

4.1.1. Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад хамаарах хуулийн этгээдийн зээлийн мэдээллийг Монголбанкнаас авах;

4.1.2. Монголбанктай гэрээ байгуулсан Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад хамаарах хуулийн этгээдийн жагсаалтыг авах;

4.1.3. Зээлийн мэдээллийн тухай хууль, тогтоомжийг зөрчсөн Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад хамаарах хуулийн этгээдэд хариуцлага тооцох;

#### 4.2. Санхүүгийн зохицуулах хороо дараах үүрэгтэй:

4.2.1. Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад хамаарах хуулийн этгээдийн зээлийн мэдээллийн санд нийлүүлсэн зээлийн мэдээллийн үнэн зөв, бодит байдалд тогтмол хяналт тавих, нийцүүлэх арга хэмжээг авч ажиллах;

4.2.2. Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад хамаарах хуулийн этгээдийн санхүүгийн тайлан мэдээг Монголбанкны зээлийн мэдээллийн санд нийлүүлэгдсэн зээлийн мэдээлэлтэй улирал бүр тулган баталгаажуулах;

4.2.3. Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад хамаарах тусгай зөвшөөрөл хүчингүй болсон эсхүл татан буугдсан хуулийн этгээдийн зээлийн мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд шинэчлэх хүсэлт, холбогдох шийдвэрийг тухай бүр Монголбанканд хүргүүлэх;

4.2.4. Зээлийн мэдээллийн тухай хууль, тогтоомжийн дагуу Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад хамаарах хуулийн этгээдийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэхийг шаардах;

4.2.5. Иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн өргөдөл, гомдлын дагуу Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад хамаарах хуулийн этгээдийн зээлийн мэдээллийн санд нийлүүлсэн зээлийн мэдээлэлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэж хариу хүргүүлэх.

### **Тав. Мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгчийн эрх үүрэг**

5.1. Мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгч нь Зээлийн мэдээллийн тухай хуульд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

#### 5.2. Мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгч дараах эрхтэй:

5.2.1. Зээлийн мэдээллийн сангийн үнэн зөв, бодит байдлыг хангах зорилгоор өөрийн нийлүүлсэн зээлийн мэдээллийг авах;

5.2.2. Өөрийн Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн хандалт, лавлагааны тайланг авах;

5.2.3. Иргэн, хуулийн этгээдийн анхны шаардлагаар зээлийн мэдээллийн лавлагааг гаргаж өгөхдөө Монголбанкны үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөлийн дагуу хураамжийн төлбөр шаардах.

#### 5.3. Мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгч дараах үүрэгтэй:

5.3.1 Монголбанктай байгуулсан гэрээний үндсэн дээр Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т заасан мэдээллийг Монголбанкнаас баталсан өгөгдөл нийлүүлэх протоколын дагуу нийлүүлнэ;

5.3.2. Зээлийн мэдээллийг засварлах, устгахтай холбоотой гаргасан зээлдэгчийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх, хэрхэн шийдвэрлэсэн талаар хариу хүргүүлэх;

5.3.3. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос шаардсан зээлдэгчтэй холбоотой мэдээлэл, баримт, материалыг заасан хугацаанд ирүүлэх;

5.3.4. Иргэн, хуулийн этгээдийн анхны хүсэлтийн дагуу зээлийн лавлагааг гаргаж өгөх;

5.3.5. Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаар иргэн, хуулийн этгээдэд үнэн зөв мэдээлэл, тайлбар өгөх, сургалт зохион байгуулах;

5.3.6. Зээлийн мэдээллийн сан хариуцсан ажилтан өөрчлөгдөх тухай бүрт Монголбанканд мэдэгдэх, зээлийн мэдээллийн нууцын баталгаа ирүүлж, зээлийн мэдээллийн тухай сургалтад хамрагдах;

5.3.7 Зээлийн мэдээллийн сангийн лавлагааны сарын хураамжийг Монголбанкны үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөлийн дагуу дараа сарын 20-ны өдөр багтаан Монголбанкны орлогын дансанд төлөх.

## **Зургаа. Зээлдэгчийн эрх үүрэг**

6.1. Зээлдэгч дараах эрхтэй:

6.1.1. Өөрийн зээлийн лавлагааг Монголбанктай гэрээ байгуулсан хэрэглэгчээс холбогдох үйлчилгээний хураамж, шимтгэлийг төлсний үндсэн дээр авах;

6.1.2. Өөрийн зээлийн лавлагааг зөвхөн Төрийн үйлчилгээний портал системээр дамжуулан хүссэн үедээ үзэж, хяналт тавих, тухайн лавлагааг жилд нэг удаа үнэ төлбөргүй авах;

6.1.3. Монголбанкны зээлийн мэдээллийн сан дахь мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэд бус тохиолдолд мэдээллийг шинэчлэхийг мэдээлэл нийлүүлэгчээс шаардах;

6.2. Зээлдэгч дараах үүрэгтэй:

6.2.1. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан өөрийн мэдээллийг зээлдүүлэгчид үнэн зөв тайлагнах;

6.2.2. Өөрийн зээлийн мэдээлэлд хууль бусаар нэмэлт, өөрчлөлт оруулсан байвал энэ талаар хуулийн байгууллагад нэн даруй мэдэгдэх;

## **Долоо. Хураамж, шимтгэл**

7.1. Монголбанк Монголбанкны үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөлд заасны дагуу төрийн байгууллагаас бусад хэрэглэгчийн зээлийн мэдээллийн сангийн үйлчилгээний хураамжийн төлбөрийг дараа сарын 5-ны өдрийн дотор нэхэмжилнэ.

7.2. Монголбанк Монголбанкны үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөлийн дагуу банкны зээлийн мэдээллийн сангийн үйлчилгээний хураамжийн төлбөрийг сар бүрийн 20-ны өдрийн дотор тухайн банкны харилцах данснаас үл маргах журмаар суутган авна.

7.3. Монголбанк Монголбанкны үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөлийн дагуу банкнаас бусад хэрэглэгчийн зээлийн мэдээллийн сангийн үйлчилгээний хураамжийн төлбөрийг сар бүрийн 20-ны өдрийн дотор тухайн хэрэглэгчээр төлүүлнэ.

7.4. Монголбанк дараах үндэслэлээр зээлийн мэдээллийн сангийн үйлчилгээний хураамжийн хэмжээг өөрчлөн тогтоох эрхтэй:

7.4.1. Мэдээллийн технологийн ба техник, програм хангамжийн үйлчилгээ шинээр нэвтрүүлснээр үйл ажиллагааны болон үйлчилгээний зардалд мэдэгдэхүйц өөрчлөлт орсон;

7.4.2. Монгол Улсын эдийн засгийн голлох үзүүлэлтүүдэд мэдэгдэхүйц өөрчлөлт орсон болон бусад;

### **Найм. Хяналт, хариуцлага**

8.1. Мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулахаас татгалзсан, хүчингүй болгосон, Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг ашиглан холбогдох шийдвэр гаргаснаас үүдсэн аливаа эрсдэл, хохирлыг Монголбанк хариуцахгүй.

8.2. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд нийлүүлэхийг хориглоно.

8.3. Монголбанк дараах үндэслэлээр гэрээг хүчингүй болгоно:

8.3.1. Эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болсон, хүчингүй болсон;

8.3.2. Хуулийн этгээд татан буугдсан, үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн.

8.4. Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг Зээлийн мэдээллийн тухай хууль, тогтоомжид заасан зориулалтаас бусад зорилгоор ашигласан, гуравдагч этгээдэд аливаа хэлбэрээр задруулсан, задруулах нөхцөлийг бүрдүүлэхийг хориглоно.

8.5. Мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгч нь Зээлийн мэдээллийн тухай хууль, тогтоомж болон энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Монголбанкны зүгээс дараах арга хэмжээг авна:

8.5.1. Мэдээлэл нийлүүлэгч нь зээлийн мэдээллийг дутуу, алдаатай нийлүүлсэн тохиолдолд сануулга өгч, түүнийг засах, гүйцээх, нэмэлт оруулах арга хэмжээг нэн даруй авахыг шаардах;

8.5.2. Энэхүү журмын 8.5.1 дэх хэсэгт заасан алдааг давтан гаргасан эсхүл түүнийг засах, гүйцээх, нэмэлт оруулах арга хэмжээг нэн даруй аваагүй тохиолдолд Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн лавлагаа авах эрхийг 1 сарын хугацаагаар түдгэлзүүлэх;

8.5.3. Энэхүү журмын 8.5.1 дэх хэсэгт заасан алдааг удаа дараа гаргасан эсхүл Монголбанкны албан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн лавлагаа авах эрхийг 3-6 сарын хугацаагаар түдгэлзүүлэх;

8.5.4. Энэхүү журмын 8.5.1 дэх хэсэгт заасан алдаатай нийлүүлсэн зээлийн мэдээллийг бүрэн засварлагдах хүртэл эсхүл Монголбанкны албан шаардлагыг биелэгдэх хүртэлх хугацаанд Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн лавлагаа авах эрхийг түдгэлзүүлэх;

8.6. Банкинд энэхүү журмын 8.5.2, 8.5.3, 8.5.4 дэх заалт хамаарахгүй бөгөөд тус журмыг зөрчсөн тохиолдолд Банкны тухай болон бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

8.6. Энэхүү журмын 5.3.4-д заасан зээлийн лавлагааг ашиг олох зорилгоор гаргаж өгөхийг хориглоно.

8.7. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Зээлийн мэдээллийн тухай болон бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

8.8. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгч нь үүссэн маргааныг харилцан зөвшилцөх байдлаар шийдвэрлэнэ.

8.9. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгч нь үүссэн маргааныг харилцан зөвшилцөх байдлаар шийдвэрлэх боломжгүй тохиолдолд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

## БАТЛАВ.

Монголбанкны Зээлийн	.....
Мэдээллийн албаны дарга	гүйцэтгэх захирал
.....	.....
/	/

**МОНГОЛБАНКНЫ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САНД  
МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ, АВАХ ГЭРЭЭ  
Дугаар**

..... оны ..... дугаар сарын .....-ны өдөр

Улаанбаатар хот

Зээлийн мэдээллийн тухай хууль, Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журмын холбогдох заалтуудыг үндэслэн нэг талаас Монголбанкны Зээлийн мэдээллийн алба, нөгөө талаас ...../улсын бүртгэлийн №....., регистр № ...../, /цаашид “Мэдээлэл нийлүүлэгч, Хэрэглэгч” гэх/ хооронд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээг байгуулав.

## НЭГ. Ерөнхий зүйл

1.1. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 болон 4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь хэсэгт заасны дагуу Монголбанкны зээлийн мэдээллийн санд зээлийн мэдээлэл нийлүүлэх, Монголбанкны зээлийн мэдээллийн санг ашиглах харилцааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

1.2. Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй. Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналыг гэрээнд оролцогч тал нь нөгөө талдаа бичгээр гаргаж, харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлтийг оруулах бөгөөд энэхүү нэмэлт, өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг болно.

1.3. Энэхүү гэрээнд тусгагдсан “Мэдээлэл нийлүүлэгч” гэж Монголбанктай гэрээ байгуулсаны үндсэн дээр зээлдэгчийн зээл, төлбөрийн талаарх үүргийн талаарх мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд нийлүүлж байгаа зээлдүүлэгч, төрийн байгууллагыг, “Хэрэглэгч” гэж Монголбанктай гэрээ байгуулсаны үндсэн дээр Монголбанкны зээлийн мэдээллийн сангаас мэдээлэл авахыг хүссэн этгээдийг хэлнэ.

1.4. Мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгчийн Зээлийн мэдээллийн сан хариуцсан ажилтан ..... албан тушаалтай ..... овогтой ..... нь Монголбанкны зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэх, ашиглах эрх бүхий итгэмжлэгдсэн ажилтан болно.

## ХОЁР. Монголбанкны эрх, үүрэг

2.1. Монголбанк Зээлийн мэдээллийн тухай хуульд зааснаас гадна дараах эрхтэй:

2.1.1. Мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгчийн Монголбанкны зээлийн мэдээллийн санд хандах эрхийг олгох, зохицуулах;

2.1.2. Зээлийн мэдээллийн тухай хууль тогтоомж, энэхүү гэрээг зөрчсөн хэрэглэгчийн мэдээлэл авах эрхийг түр хугацаагаар түдгэлзүүлэх, хаах;

2.1.3. Эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болсон, цуцлагдсан, хүчингүй болсон, татан буугдсан тохиолдолд гэрээ цуцлах;

2.1.4. Зээлийн мэдээллийн тухай хууль тогтоомжийн дагуу зээлийн мэдээллийн үнэн бодит байдлыг хангуулах хүрээнд мэдээлэл нийлүүлэгчийн нийлүүлсэн зээлийн мэдээлэлтэй холбоотой нэмэлт мэдээлэл, баримт материал гаргуулан авах;

2.1.5. Мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгчийн зээлийн мэдээлэлтэй холбоотой статистик мэдээлэл гаргуулан авах;

2.1.6. Зээлийн мэдээллийн тухай хууль тогтоомжид заасан зээлийн мэдээллийн шаардлагыг хангаагүй тохиолдолд нийцүүлэхийг шаардах;

2.1.7. Мэдээлэл нийлүүлэгчээс Монголбанкны зээлийн мэдээллийн санд нийлүүлсэн мэдээллийг Зээлийн мэдээллийн тухай хууль тогтоомжийг дагуу ашиглах;

2.1.8. Зээлийн мэдээллийн тухай хууль тогтоомжийг мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгчээр дамжуулан олон нийтэд сурталчлах, сургалт зохион байгуулах;

2.1.9. Санхүүгийн зуучлал, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар Зээлийн лавлагаанд шаардлагатай гэж үзсэн мэдээллийг тусгах, эс тусгах, мэдээлэлд өөрчлөлт оруулах арга хэмжээ авах;

2.1.10. Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн програм, техник тоног төхөөрөмжийг шинэчлэх хугацаанд зээлийн мэдээллийн үйл ажиллагааг тодорхой хугацаагаар зогсоох;

2.1.11. Зээлийн мэдээллийн санд шаардлагатай шинэчлэлийг гүйцэтгэх, найдвартай тасралтгүй байдлыг хангах, хүчин чадлыг нэмэгдүүлэх, үйлчилгээг боловсронгуй болгох зорилгоор хэрэглэгчээс хураамж, шимтгэл авах;

2.1.12. Монголбанкны үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөлд заасны дагуу хэрэглэгчийн зээлийн мэдээллийн сангийн үйлчилгээний хураамжийн төлбөрийг дараа сарын 5-ны өдрийн дотор нэхэмжлэх, банкны зээлийн мэдээллийн сангийн үйлчилгээний хураамжийн төлбөрийг сар бүрийн 20-ны өдрийн дотор тухайн банкны харилцах данснаас үл маргах журмаар суутган авах;

2.1.13. Монголбанкны үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөлд заасан хураамж, шимтгэлийг энэхүү журамд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд төлбөр төлөх эцсийн хугацаанаас хойш 6 сарын дараа мэдээлэл хэрэглэгчийн нэр дээр шүүхэд нэхэмжлэл гаргах.

2.2. Монголбанк Зээлийн мэдээллийн тухай хуульд зааснаас гадна дараах үүрэгтэй:

2.2.1. Монголбанк зээлийн мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагааг хуанлийн өдрүүдэд 24 цагийн турш эрхлэх, хөгжүүлэх, програмд гарсан алдаа доголдлыг хурдан шуурхай засах, техник тоног төхөөрөмжийн найдвартай байдлыг хангах;

2.2.2. Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журмын дагуу Монголбанкны зээлийн мэдээллийн санг бүрдүүлэх;

2.2.3. Монголбанкны зээлийн мэдээллийн санд нийлүүлсэн зээлийн мэдээллийг хадгалах, хамгаалах;

2.2.4. Тусгай зөвшөөрөл хүчингүй болсон эсхүл татан буугдсан мэдээлэл нийлүүлэгчээс нийлүүлсэн зээлийн мэдээллийг зохицуулагч байгууллагын тодорхойлолтыг үндэслэн засварлах, устгах арга хэмжээ авах;

2.2.5. Шүүхийн шийдвэрийн дагуу мэдээлэл нийлүүлэгчээс Монголбанкны зээлийн мэдээллийн санд нийлүүлсэн зээлийн мэдээллийг засварлах, устгах;



2.2.6. Мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгчид зээлийн мэдээллийн сангийн програм ашиглалт, мэдээлэл нийлүүлэлттэй холбоотой асуудлаар зааварчилгаа, зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;

2.2.7. Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаар олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, харилцагчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгчтэй хамтран ажиллах;

2.2.8. Шаардлагатай тохиолдолд мэдээлэл нийлүүлэгчээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Монголбанкны зээлийн мэдээллийн санд нийлүүлэгдсэн зээлийн мэдээллийн тайланг гаргах;

2.2.9. Зээлийн мэдээлэлтэй холбоотой зээлдэгчээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг мэдээлэл нийлүүлэгчид хүргүүлэн шийдвэрлүүлэх, хяналт тавих;

2.2.10. Зээлийн мэдээллийн тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг сахин биелүүлэхтэй холбоотой арга хэмжээг тухай бүр авах.

### ГУРАВ. Мэдээлэл нийлүүлэгчийн эрх, үүрэг

3.1. Мэдээлэл нийлүүлэгч нь Зээлийн мэдээллийн тухай хуульд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

3.2. Мэдээлэл нийлүүлэгч нь энэхүү гэрээний 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт зааснаас гадна дараах эрхтэй:

3.2.1. Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн үнэн зөв, бодит байдлыг хангах зорилгоор өөрийн нийлүүлсэн зээлийн мэдээллийг авах;

3.2.2. Өөрийн Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн хандалт, лавлагааны тайланг авах;

3.3. Мэдээлэл нийлүүлэгч нь энэхүү гэрээний 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт зааснаас гадна дараах үүрэгтэй:

3.3.1. Мэдээлэл нийлүүлэгч нь дараах шаардлагыг байнга хангаж ажиллана:

3.3.1.1. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь хэсэгт заасан этгээд байх;

3.3.1.2. Зээлийн мэдээлэл нийлүүлэхэд шаардлагатай хүний нөөц, техник, тоног төхөөрөмж, програм хангамжаар хангагдсан байх;

3.3.1.3. Зээлийн мэдээллийн сан хариуцсан ажилтны эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой тусгасан ажлын байрны тодорхойлолтыг баталж, мөрдүүлэх;

3.3.2. Монголбанкт байгуулсан гэрээний үндсэн дээр Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-г заасан мэдээллийг Монголбанкнаас баталсан өгөгдөл нийлүүлэх протокол, уг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан хугацаанд нийлүүлэх, нийлүүлсэн мэдээлэлд өөрчлөлт оруулах;

3.3.3. Мэдээлэл нийлүүлэгч нь зээлийн мэдээллийг засварлах, устгахтай холбоотой гаргасан зээлдэгчийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх, хэрхэн шийдвэрлэсэн талаар хариу хүргүүлэх;

3.3.4. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос шаардсан зээлдэгчтэй холбоотой нэмэлт мэдээлэл, баримт, материалыг заасан хугацаанд ирүүлэх;

3.3.5. Монголбанкны зээлийн мэдээллийн санд нийлүүлж буй зээлийн мэдээллийн (мэдээлэл, тоног төхөөрөмж, програм хангамж) нууцлал, аюулгүй байдлыг хангах;

3.3.6. Мэдээлэл нийлүүлэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ байгалийн давагдашгүй хүчин зүйл болон бусад нөхцөл байдлаас шалгаалан гүйцэтгэх боломжгүй

болсон тохиолдолд Монголбанкны зээлийн мэдээллийн албанд энэ талаар ажлын 5 хоногийн дотор мэдэгдэх;

3.3.7. Мэдээлэл нийлүүлэгчийн хуулийн этгээдийн хэлбэр, бүртгэлтэй хаяг, удирдлага, зээлийн мэдээллийн сан хариуцсан ажилтан өөрчлөгдөх тухай бүрт Монголбанкны зээлийн мэдээллийн албанд мэдэгдэж, энэхүү журмын хавсралтын дагуу нууцын баталгаа гаргах;

3.3.8. Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаар иргэн, хуулийн этгээдэд үнэн зөв мэдээлэл, тайлбар өгөх, сургалт зохион байгуулах;

#### ДӨРӨВ. Хэрэглэгчийн эрх, үүрэг

4.1. Хэрэглэгч нь Зээлийн мэдээллийн тухай хуульд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

4.2. Хэрэглэгч нь энэхүү гэрээний 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт зааснаас гадна дараах эрхтэй:

4.2.1. Энэхүү гэрээний үндсэн дээр Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т заасан мэдээллийг ашиглах;

4.2.2. Иргэн, хуулийн этгээдэд зээлийн лавлагааг өгөхдөө Монголбанкны үйлчилгээний шимтгэл, хураамжийн ерөнхий нөхцлийн дагуу үйлчилгээний шимтгэл, хураамж авах;

4.2.3. Өөрийн Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн хандалт, лавлагааны тайланг авах;

4.3. Хэрэглэгч нь энэхүү гэрээний 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт зааснаас гадна дараах үүрэгтэй:

4.3.1. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос Зээлийн мэдээллийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан зорилгоор Монголбанкны зээлийн мэдээллийн санг ашигласан эсэх талаарх нэмэлт мэдээлэл, баримт, материалыг заасан хугацаанд ирүүлэх;

4.3.2. Иргэн, хуулийн этгээдийн анхны хүсэлтийн дагуу зээлийн лавлагааг гаргаж өгөх;

4.3.3. Монголбанкны зээлийн мэдээллийн сангаас ашиглаж буй мэдээлэл (мэдээлэл, тоног төхөөрөмж, програм хангамж)-ийн нууцлал, аюулгүй байдлыг хангах;

4.3.4. Хэрэглэгчийн хуулийн этгээдийн хэлбэр, бүртгэлтэй хаяг, удирдлага, зээлийн мэдээллийн сан хариуцсан ажилтан өөрчлөгдөх тухай бүрт Монголбанкны зээлийн мэдээллийн албанд мэдэгдэж, энэхүү журмын хавсралтын дагуу нууцын баталгаа гаргах;

4.3.5. Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаар иргэн, хуулийн этгээдэд үнэн зөв мэдээлэл, тайлбар өгөх, сургалт зохион байгуулах;

4.3.6. Зээлийн мэдээллийн сангийн лавлагааны сарын хураамжийн төлбөрийг Монголбанкны үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөлийн дагуу дараа сарын 20-ны өдрийн дотор багтаан Монголбанкны орлогын ..... дансанд төлөх;

#### ТАВ. Хариуцлага

5.1. Энэхүү гэрээний хүрээнд олж авсан зээлийн мэдээллийг Зээлийн мэдээллийн тухай хууль, Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журамд заасан зориулалтаас бусад зорилгоор ашигласан, гуравдагч этгээдэд аливаа хэлбэрээр задруулсан, задруулах нөхцөлийг бүрдүүлэхийг талуудад хориглоно.

5.2. Мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгч нь энэхүү гэрээний 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт дурдсан үйлдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, мэдээлэл нийлүүлэх, ашиглахтай холбоотой журам, зааврыг батлан Монголбанкны зээлийн мэдээллийн албанд хүргүүлж, өөрийн үйл ажиллагаандаа мөрдөнө.

5.3. Энэхүү гэрээний 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт дурдсан нэг талын үйлдэл нь Эрүүгийн болон холбогдох бусад хууль тогтоомж зөрчсөн байж болзошгүй тохиолдолд энэ талаар зохих эрх бүхий байгууллагад гэрээний нөгөө тал шуурхай мэдээлнэ.

5.4. Монголбанк нь энэхүү гэрээний 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт дурдсан журам, зааврыг гэрээний 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасан тохиолдолд эрх бүхий байгууллагад хүргүүлж болно.

5.6. Энэхүү гэрээг зөрчсөний улмаас бусдад учирсан аливаа хохирлыг тухайн зөрчлийг гаргасан тал бүрэн хариуцна.

5.7. Энэхүү гэрээг байгуулахаас татгалзсан, хүчингүй болгосон, Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг ашиглан холбогдох шийдвэр гаргаснаас үүдсэн аливаа эрсдэл, хохирлыг Монголбанк хариуцахгүй.

5.8. Энэхүү гэрээний 4 дүгээр зүйлийн 4.3.2 дахь хэсэгт заасан зээлийн лавлагааг ашиг олох зорилгоор гаргаж өгөхийг хориглоно.

5.9. Мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгч нь Зээлийн мэдээллийн тухай хууль, тогтоомж болон энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Монголбанкны зүгээс дараах арга хэмжээг авна:

5.9.1. Мэдээлэл нийлүүлэгч нь зээлийн мэдээллийг дутуу, алдаатай нийлүүлсэн тохиолдолд сануулга өгч, түүнийг засах, гүйцээх, нэмэлт оруулах арга хэмжээг нэн даруй авахыг шаардах;

5.9.2. Энэхүү журмын 5 дугаар зүйлийн 5.8.1 дэх хэсэгт заасан алдааг давтан гаргасан эсхүл түүнийг засах, гүйцээх, нэмэлт оруулах арга хэмжээг нэн даруй аваагүй тохиолдолд Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн лавлагаа авах эрхийг 1 сарын хугацаагаар түдгэлзүүлэх;

5.9.3. Энэхүү журмын 5 дугаар зүйлийн 5.8.1 дэх хэсэгт заасан алдааг удаа дараа гаргасан эсхүл Монголбанкны албан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн лавлагаа авах эрхийг 3-6 сарын хугацаагаар түдгэлзүүлэх;

5.9.4. Энэхүү журмын 5 дугаар зүйлийн 5.8.1 дэх хэсэгт заасан алдаатай нийлүүлсэн зээлийн мэдээллийг бүрэн засварлагдах хүртэл эсхүл Монголбанкны албан шаардлагыг биелэгдэх хүртэлх хугацаанд Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн лавлагаа авах эрхийг түдгэлзүүлэх;

## ЗУРГАА. Бусад зүйл

6.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

6.2. Мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгчийн зээлийн мэдээллийн сан хариуцсан ажилтан нь гэрээний хавсралтын дагуу нууцлалын баталгаа гаргаж Монголбанкны зээлийн мэдээллийн албанд ирүүлнэ.

6.3. Гэрээг 2 /хоёр/ хувь үйлдэх бөгөөд хувь тус бүр нь хуулийн дагуу адил хүчин төгөлдөр байна.

6.4. Энэхүү гэрээгээр зохицуулаагүй харилцаа болон гэрээтэй холбоотой маргааныг харилцан тохиролцоо замаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд харилцан тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### ТАЛУУДЫГ ТӨЛӨӨЛЖ:

Монголбанкны Зээлийн мэдээллийн  
албаны дарга

.....

/ /

.....

/ /

Монголбанкны Зээлийн  
мэдээллийн албаны хянан шалгагч

.....

/ /

Итгэмжлэгдсэн эрх  
бүхий ажилтан

.....

/ /

## НУУЦЫН БАТАЛГАА

Нууцын баталгаа гаргаж буй ажилтны

1. Байгууллагын албан ёсны нэр :

2. Эрхэлж буй албан тушаалын нэр :

3. Регистрийн дугаар :

4. Утасны дугаар :

5. Цахим хаяг:

6. Байгууллагын захирлын нэр, утасны дугаар:

\_\_\_\_\_ны \_\_\_\_\_ миний бие албан үүргийн дагуу иргэд, аж ахуйн нэгжийн зээлийн мэдээллийн мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд нийлүүлэхдээ нууцлалыг чанд хадгалж, хамгаалахаа баталж байна. Хэрэв би Зээлийн мэдээллийн тухай хууль тогтоомжийг зөрчин иргэн, аж ахуйн нэгжийн зээл, тэдгээртэй холбоотой бусад мэдээлийн нууцыг задруулснаас үүдэн бусдын эрх ашгийг хөндөж, ямар нэг байдлаар хохирол учруулбал Монгол Улсын Эрүүгийн болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээх болно.

БАТАЛГАА ГАРГАСАН

(гарын үсэг)

БАТАЛГАА ГАРГУУЛСАН:

(гарын үсэг)

*/Байгууллагын тэмдэгээ дарна уу/*

**Баталгаа гаргуулсан албан тушаалтны:**

*Эцгийн болон өөрийн нэр*

*Албан тушаалын нэр*

*Ажлын болон гар утасны дугаар*

..... оны ..... сарын ..... өдөр